



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 4/23

Модот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.4, 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр малын халдварт өвчнөөс урдчилан сэргийлэх, сэг зэмийн устгал хийх, байгаль орчныг хамгаалах олон үйлдэлт бага оврын трактор худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга Б.Ганзориг - Засаг даргын орлогч
Үнэлгээний хорооны нарийн бичиг Ж.Тодбилэг - Байгаль хамгаалагч
Үнэлгээний хорооны гишүүн

Д.Өсөхгэрэл - Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Э.Баяржаргал - Иргэн

Э.Энхмандах - Хөдөлмөр эрхлэлт, асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлыг хуулийн хүрээнд чанартай зохион байгуулж зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хугацаанд нь хүргүүлж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Б.Ганзориг) –д үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ

